



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

ГДуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа "Шохой Тоосгоны Нэгдэл" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, 18,100,000.00 (арван найман сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Н.Нандинболор нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132030657
9-r huraldaan.docx

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 онь дүгээр сарын 17-ны өдрийн

207 дугаар тогтоолын хавсралт

ШУҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ "ШОХОЙ ТООСГОНЫ НЭГДЭЛ" ТӨРИЙН ёМЧИТ АЖ АХУЙН ТООЦОУТ УЙДВЭРИЙН
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААНТ

| Д/д | Автомашины нэр, марк, улсын дугаар, аарал, хөдөлгүүрийн дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Балансын нийт үнэ (төгрөг) | Хуриимлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдээгдэл өртөг (төгрөг) | ТӨБЗГ-ЫН 2024 ОНЫ 489 дүгээр тогтооюор тогтоосон досд үнэ (төгрөг) | Шинэчлан тогтоосон худалдах доод үнэ (төгрөг) |
|-----|--|-----------------------------------|--|--|--------------------------|--|---|
| 1 | УАЗ Фургон 46-28 ТӨА, /374100A0418658/ Нийт үнэ | 2010/2010 | 18,100,000.00 (арван найман сая нэг зүйн мянга) | 18,100,000.00 (арван найман сая нэг зүйн мянга) | - | 1,500,000.00 (нэг сая таван зуун мянга) | 750,000.00 (доллоон зуун тавин сая) |